

# МӨРИЙН ХӨТӨЛБӨР



## Ардчилсан намын мөрийн хөтөлбөрөөс:

### ЗАЛУУЧУУД



- Орон нутагт ажиллаж буй залуучуудыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, илүү үр дүнтэй хэлбэрээр шинэчлэн зохион байгуулна.

### АХМАДУУД



- Ахмадын эрүүл мэндийн тогтолцоог сайжруулна.
- Тэтгэврийг цалингийн өсөлт, инфляцийн түвшинтэй уялдуулах бодлого баримтална.
- Ахмад настанд зориулсан бүсчилсэн сэргээн засах эмчилгээ, сувилгааны цогцолбор төвүүдийг аймаг, нийслэлд байгуулж, хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

### БИЗНЕС, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ



- Цалин хөлсийг ажлын байранд өнгөрүүлсэн хугацаагаар бус ажлын үр дүнгээр тооцдог аргачлалыг нэвтрүүлнэ.
- Жижиг, дунд болон бичил үйлдвэрлэл эрхлэгчдийг гадаад зах зээлд гарах, хил орчмын худалдаанд идэвхтэй оролцоход нь дэмжлэг үзүүлнэ.
- Баялаг бүтээгчдээ дэмжиж, монгол хүний орлогыг нэмэгдүүлнэ.

### МАЛ АЖ АЖУЙ



- Мал, малын гаралтай бүх төрлийн түүхий эд, бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтийг хурдасгах замаар малчдын амьжиргаа, орлогыг дээшлүүлэх нөхцөл бүрдүүлнэ.
- Мах, сүү, шувуу, зөгийний эрчимжсэн фермерийн аж ахуй эрхлэх иргэн, аж ахуйн нэгжийг хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжинэ. Хот, аймгийн төв, томоохон суурин газрын хүнсний хангамжийг сайжруулна.

### ГАЗАР ТАРИАЛАН



- Газар тариалангийн бүс нутагт услалтын системийн менежментийг боловсронгуй болгож, тариалан эрхлэгч, хүнсний ногоо тариалагчдыг бодлогоор дэмжинэ.

### БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР



- Зэсийн баяжмал, алт, мөнгө хайлуулж, цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулах, зэс болон хайлш бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүдийг байгуулахыг дэмжинэ.
- Ноос боловсруулах үйлдвэрийг сэргээж, ноосон эдлэл, бүтээгдэхүүн, ялангуяа шинэ бүтээгдэхүүн болох ноосон бордоо, ноосоор хийсэн барилгын дулаалга бүтээгдэхүүнийг экспортлоход анхаарна.

### БАЙГАЛЬ ОРЧИН, УУЛ УУРХАЙ



- Саарал усны ашиглалтыг нэмэгдүүлж, орчин үеийн цэвэршүүлэх байгууламжын стандартыг нэвтрүүлэх чиглэл, бодлогыг хэрэгжүүлнэ.
- Хариуцлагатай уул уурхайн зарчмын дагуу нөхөн сэргээлт, хаалтын асуудлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж бүрэн хариуцан гүйцэтгэдэг болгоно.